



**ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗАР**

ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ОАХХААГ-2025/07/-08



**Орхон аймаг
2025 он**

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	2
Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Б.Батжаргал	БҮЛЭГ 1. Ерөнхий зүйл	3
	1.1. Ерөнхий мэдээлэл	3
	1.2. Аудитын зорилго, үндэслэл	3
	1.3. Дотоод хяналт шалгалтын арга зүй	3
	1.4. Аймгийн Засаг даргын Захирамжийн боловсруулалт, санхүүжилтийн явц	3
	1.5. Дотоод хяналтад хамрагдсан асуудал	4
	БҮЛЭГ 2. Батлагдсан төсөл хөтөлбөр, захирамж, санхүүжилтийн мэдээлэл	4
	БҮЛЭГ 3. Санхүүгийн анхан шатны баримт, зарцуулалт, үр дүн	6
	БҮЛЭГ 4. 2024 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	9
2025 оны 11 сарын 06-ны өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл	Дүгнэлт	9
	Зөвлөмж	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94209421 утсаар харилцана уу.	Дотоод хяналт хэрэгжүүлсэн мэргэжилтний санал	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХАА	Хөдөө аж ахуй
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЗУХ	Хүнс, хөдөө аж ахуйн Захиргаа, удирдлагын хэлтэс
МААХ	Мал аж ахуйн хэлтэс
ЗААА	Захиргаа аж ахуйн алба
ҮХҮА	Үйлдвэр, худалдаа үйлчилгээний алба
МААА	Мал аж ахуйн алба
ХА	Хяналтын алба
БНШК	Баримт нягтлан шалгах комисс

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Ерөнхий мэдээлэл:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 08 дугаартай удирдамжийн дагуу байгууллагад хэрэгжүүлсэн аймгийн Засаг даргын Захирамжийн хэрэгжилтийн байдалд дотоод хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батжаргал 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэхээр удирдамжийг батлуулсан. Захирамжийн хэрэгжилтэд дотоод хяналт хийхдээ санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлт, төсвийн дагуу зарцуулсан эсэх, үр дүн, үр нөлөө, өмнөх 2024 оны зөвлөмжийн хэрэгжилт зэргээр дотоод хяналтыг 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 11 дүгээр сарын 14-ний хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.2 Аудитын зорилго, үндэслэл:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 7.4 дэх хэсэг, “Хүнс, хөдөө аж ахуйн газрын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, дотоод хяналт шалгалт хийх 2025 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагад хэрэгжүүлж буй Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хэрэгжилтийг хангахад дотоод аудитын зорилго оршино.

1.3 Дотоод хяналт шалгалтын арга зүй:

Байгууллагад хэрэгжүүлж буй Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд дотоод хяналт хийхдээ санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө, өмнөх дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчлийг залруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, давтан гаргахгүй байх арга хэмжээ авах, хууль, журмыг мөрдүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж, зөвлөгөө өгч, санал боловсруулахад чиглэгдлээ.

1.4 Аймгийн Засаг даргын Захирамжийн боловсруулалт, санхүүжилтийн явц:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааг тогтвортой хангах, тухайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” аймгийн ИТХ-ын 2025 оны 03/13 дугаар тогтоолын дагуу Захирамжийн төслийг хариуцсан мэргэжилтэн боловсруулж, ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн салбар хариуцсан мэргэжилтэн хянаж, батлуулан, ахлах нягтлан бодогч санхүүжилтийн асуудлыг Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам бусад холбогдох хууль, журмын дагуу байгууллагад шилжүүлэн, анхан шатны баримтад тулгуурлан зарцуулж, хэрэгжилтийг хангаж буй

мэргэжилтэн анхан шатны баримт, төсвийн зарцуулалт, үр дүн хариуцан, тайлагнаж байна.

1.5 Дотоод хяналтад хамрагдсан асуудал:

Байгууллагын үндсэн чиг үүрэг буюу салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан Захирамжийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хийхдээ:

- 2025 онд батлагдсан төсөл хөтөлбөр, захирамж, санхүүжилтийн мэдээлэл
- Санхүүгийн анхан шатны баримт, зарцуулалт
- Үр дүн, үр нөлөө
- Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг тус тус шалгалаа.

ХОЁР: БАТЛАГДСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ЗАХИРАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын 2025 оны “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 03/13 дугаар тогтоолын 5.1 дэх хэсгийн Төсөл хөтөлбөрийн зардалд нийт 12,328,979.9 мянган төгрөг батлагдсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хангах, салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр 882,000,000.00 төгрөг буюу 10 багц төсөл арга хэмжээ батлагдсан Үүнд:

Аймгийн төсвөөс 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт

(мян.төгрөг)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	2	3	4	5	6
2.4.64	"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зардал	2025	2025	35,000.00	35,000.00
2.4.65	Хүн амын хаврын хэрэгцээнд махны нөөц бүрдүүлэх зардал	2025	2025	400,000.00	400,000.00
2.4.66	Мал аж ахуйн салбарыг дэмжин хөгжүүлэх зардал	2025	2025	15,000.00	15,000.00
2.4.67	"Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	2025	2025	50,000.00	50,000.00
2.4.68	"Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх зардал	2025	2025	8,000.00	8,000.00
2.4.69	"Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III"-ыг орон нутагт хэрэгжүүлэх зардал	2025	2025	8,000.00	8,000.00

	4	3	4	5	6
2.4.70	"Өрхийн болон бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зардал	2025	2025	308,000.00	308,000.00
2.4.71	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжүүдэд хяналт, шинжилгээ хийх зардал	2025	2025	25,000.00	25,000.00
2.4.72	Улсын аварга малчид, тариаланчдад хүндэтгэл үзүүлэх зардал	2025	2025	8,000.00	8,000.00
2.4.73	Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах зардал	2025	2025	40,000.00	40,000.00
2.4.74	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, сэг зэм устгах, ариутгал халдваргүйтэл хийх зардал	2025	2025	25,000.00	25,000.00
2.4.75	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах (НАССР) болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зардал	2025	2025	25,000.00	25,000.00

2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар нийт 18 захирамжийн 268,685,000 төгрөгийн санхүүжилтийн орлогын гүйлгээ хийгдсэнээс 47,575,000 төгрөгийн 10 захирамж бүрэн хэрэгжиж буюу мөнгөн дүнгийн 17.7 хувийг дотоод хяналтад хамрууллаа. 2025 он эхний хагас жилийн байдлаар нийт 13 захирамж батлагдсан бөгөөд 10 захирамжийн материал ирсэн нь хангалтгүй байна.

Орлогын гүйлгээ хийгдсэн 18 захирамжийн мэдээлэл:

№	Тэргүү, утга	Гүйлгээ хийсэн огноо	Захирамжийн дугаар	Мөнгөн дүн
1.	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр	2025.02.11	A/92	50,000,000
2.	Улсын аварга малчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлэх	2025.02.11	A/93	8,000,000
3.	Улсын байцаагчдын хяналт шалгалтын зардал	2025.02.20	A/137	5,200,000
4.	Малчдын өвөлжилт, хаваржилт, мал төлөлтийн явцтай танилцах	2025.03.12	A/170	4,200,000
5.	Нөөцийн махны үйлчилгээнд хяналт тавих	2025.03.18	A/203	2,500,000
6.	Үржлийн малд үзлэг ангилалт хийх	2025.03.26	A/223	4,350,000
7.	Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний-3	2025.04.25	A/339	8,000,000
8.	Хаврын тариалалтыг технологийн хугацаанд хийх	2025.05.21	A/393	775,000
9.	Аймгийн аварга тогооч шалгаруулах	2025.05.21	A/423	7,000,000
10.	Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг дэмжих	2025.05.30	A/445	4,850,000

11.	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих	2025.06.13	A/451	3,250,000
12.	Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх	2025.06.13	A/452	8,000,000
13.	Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих	2025.06.24	A/529	8,000,000
14.	Хяналт шинжилгээ үнэлгээ зохион байгуулах	2025.06.26	A/543	3,000,000
15.	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих	2025.07.04	A/533	21,750,000
16.	Аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээл бэлтгэх	2025.09.05	A/720	123,400,000
17.	Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2025 нэгдсэн арга хэмжээ	2025.09.16	A/746	5,544,000
18.	Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн	2025.09.24	A/747	866,000
Нийт дүн				268,685,000

ГУРАВ: САНХҮҮГИЙН АНХАН ШАТНЫ БАРИМТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

№	Дугаар, мөнгөн дүн /мян.төг/	Зорилт	Хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт, үр дүн	Анхаарах асуудал
1	Улсын аварга малчин, тариаланчд ад хүндэтгэл үзүүлэх А/93 8,000.0	Сар шинийн баярыг тохиолдуулан мал аж ахуй, газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажилласан Аймгийн аварга малчин, саальчин, тариаланч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүндэтгэл үзүүлэх	Төсөв: Аварга малчин 3 ирэнд 3.0 сая төгрөг Аварга саальчин 1 иргэнд 1.0 сая төгрөг Аварга тариаланч 3 иргэн, аж ахуйн нэгжид 3.0 сая Дурсгалын зүйл 2, 1.0сая төгрөг. Төсөл хөтөлбөрийн 2.4.72 зардлаас гаргуулахаар батлуулсан. Зарцуулалт: Аварга малчны тэмдэг 3ш 165,000 Өргөмжлөл 1ш 840,000 Мөнгөн аяга 2ш 960,000 Хадаг 2ш 40,000 Тууз 7ш 280,000 Тэмдэг 4ш 220,000 Үнэмлэх 7ш 35,000 Хайрцаг 7ш 70,000 Саальчин шагналын мөнгө 1ш 770,000 Тариаланч шагналын мөнгө 1ш 770,000 Саальчин шагналын мөнгө 1ш 770,000 Тариаланч шагналын мөнгө 1ш 770,000 Аварга малчны шагналын мөнгө 1ш 770,000 Тариаланч шагналын мөнгө 1ш 770,000 Аварга малчны шагналын мөнгө 1ш 770,000 Нийт зарцуулалт 8,000,000 төгрөг. Захирамжийн үр дүн хангагдсан.	-Төлбөрийн баримт нөхөж хийх -Мөнгөн шагналын зардалд иргэний үнэмлэх, гэрчилгээ хавсаргах -Төсөв, гүйцэтгэл зөрүүтэй, -Аймгийн аварга малчныг саалчин гэж утга андуурч гүйлгээ хийсэн.
2	Улсын байцаагчдын хяналт шалгалтын	1.Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Сургалтад: Бичиг хэрэг 480,000 Принтерийн хор 520,000 Заал болон багшийн хөлс 4,200,000	-Хоол үйлдвэрлэл эрхэлдэг сургууль, цэцэрлэгийн 121 албан хаагч ирэхээс

	зардал A/137 5,200.0	2.Сургалт зохион байгуулах, сурталчлах	Төсөл хөтөлбөрийн 2.4.64 зардлаас гаргуулахаар батлуулсан. Бичиг хэрэг 532,500+467500/540500 хор+459500/ Сургалтын заал, техник 2,400,000 Багшийн төлбөр 800,000 Багшийн төлбөр 1,000,000 Нийт зарцуулалт 5,200,000 төгрөг. 214+39 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан. Төлөвлөснөөс бичиг хэрэг, хорын зардал 8,000 төгрөгөөр гүйсэн. Захирамжийн үр дүн хангагдсан.	30 шалтгаангүй тасалсан. -Сургалтын 2 хөтөлбөрийн огноо 2024 оноор байна. -Гэрээ дүгнэсэн акт үйлдэх
3	Нөөцийн махны үйлчилгээнд хяналт тавих A/203 2,500.0	Нөөцийн махны үнэ, борлуулж буй цэгийн талаарх мэдээллийг хэрэглэгчдэд тогтмол хүргэх, нөөцийн махны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, махны хадгалалт, жижиглэн ангилан савлалт, борлуулалт, хүртээмжийн байдалд өдөр тутмын хяналт хийх, хэрэглэгчдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллах	Эх бэлтгэл 31ш-155,000 Хэвлэх 93м.кв-1,488,000 Прүс мод 53ш-371,000 Шатахуун 195л-486,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.64 зардлаас гаргуулахаар батлуулсан. Шатахуун 486,000+20400/хэтэвч/ Хэвлэх 1,643,000 Прүс мод 371,000 Нийт зарцуулалт 2,500,000 төгрөг. Тайланг зорилготой уяж, үр дүнг тооцож, бүрэн тайлагнасан. Хяналт гэдэг үгийг 2 өгүүлбэрт хаяж бичсэн нь өгүүлбэрийн утгийг алдагдуулж байна. Захирамжийн үр дүн хангагдсан.	-Бичмэл тайлан засах.
4	Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний-3 A/339 8,000.0	Хоршооны салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, 7 зорилт, 22 ажил	Сургагч багш 2,000,000 Туршлага с удлах, үзэсгэлэнд 2,500,000 Сурталчилгаа 1,000,000 Хяналт хийх 500,000 Шатахуун 2,000,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.69 зардлаас 8,000,000 гаргуулахаар батлуулсан. Шатахуун 2,500,000 Багшийн хөлс 2,000,000 Сурталчилгаа 1,000,000 Автобусны хөлс 2,500,000 Гэрээ 2% хавсаргасан. Нийт зарцуулалт 8,000,000 төгрөг.	-Төлбөрийн баримт нөхөж хийх -Гэрээ дүгнэсэн акт үйлдэх -Захирамжаар төлөвлөгөө батлуулалсан, түүний үр дүн, үр нөлөө тооцсон нэгдсэн тайлан бичих. Хэдэн хувь нь батлагдсан төсвөөр биелэгдсэн, бусад төлөвлөгөөнд тусгасан ажлыг ямар төсвөөс санхүүжүүлж, төлөвлөгөөний биелэлт хангасан. Төлөвлөгөөний нийт биелэлтийн хувь?
5	Хаврын тариалалтх ийх A/393 775.0	Аймгийн хэмжээнд хаврын тариалалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэх ажлыг шуурхай зохион байгуулж, соёололтоор хүлээн авах	Шатахуун 775,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.64 зардлаас 775,000 төгрөг гаргуулахаар батлуулсан. Шатахуун 775,386 Нийт зарцуулалт 8,000,000 төгрөг. Захирамжийн үр дүн хангагдсан.	-
6	Аймгийн аварга тогооч	Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой	Өргөмжлөл 80ш-720,000 Батламж 29ш-966,000 Медаль 56ш-1,680,000	-

	шалгаруулах A/423 7,000.0	уламжлалт хоол, идээ ундааны технологийг түгээн дэлгэрүүлэх, сарбарын ажилтан ажиллагсдын чадамж, ур чадварыг дээшлүүлэх Аймгийн аварга тогооч, Эрдэнэт фүүд фестиваль хоолны уралдаан, шоу зохион байгуулах	Цом бш-1,500,000 Анонс 48м.кв-624,000 Мандат 100ш-550,000 Хар хайрцгийн материал 960,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.64 зардлаас 7,000,000 гаргуулахаар батлуулсан. Батламж 750,000 Хар хайрцгийн материал 960,000 Өргөмжлөл, батламж, мандат, анонс 2,110,000 Нийт зарцуулалт 7,000,000 төгрөг. Зохион байгуулсан ажлын үр дүн, цаашдын үр нөлөөг сайн тодорхойлж тайлагнасан. Захирамжийн хэрэгжилт, үр дүн хангагдсан.	
7	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих A/451 3,250.0	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах	Бичиг хэрэгсэл 500,000 Телевизийн бичлэг 2,750,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.71 зардлаас 3,250,000 гаргуулахаар батлуулсан. Телевизийн бичлэг 2,750,000 Бичиг хэрэг 500,000 Нийт зарцуулалт 3,250,000 төгрөг. Захирамжийн хэрэгжилт, үр дүн хангагдсан.	-Зарцуулалтын эрхийн хүсэлт №13 засвартай -Гэрээ дүгнэсэн акт үйлдэх
8	Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих A/529 8,000.0	Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, өдөрлөг зохион байгуулах	Асар түрээс 2 өдөр 30ш-7,200,000 Хулдаас хэвлэл 45 м.кв-720,000 Ширээ түрээс 40ш-80,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.70 зардлаас 8,000,000 гаргуулахаар батлуулсан. Асар түрээс 2 өдөр 30ш-7,200,000 Хулдаас хэвлэл 45 м.кв-720,000 Ширээ түрээс 40ш-80,000 Нийт зарцуулалт 8,000,000 төгрөг. Захирамжийн хэрэгжилт хангагдсан.	-Гэрээ дүгнээгүй -Тайлан албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангаагүй
9	Хяналт шинжилгээ үнэлгээ зохион байгуулах A/543 3,000.0	2024 оны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ерөнхий дүнгээр байр эзэлж шагнагдсан тул шагнаж урамшуулах	5-р байр -3,000,000 Нийт зарцуулалт 3,000,000 төгрөг. Захирамжийн хэрэгжилт хангагдсан.	-
10	Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг дэмжих A/445 4,850.0	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, ур чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх туршлага судлуулах, сургалт зохион байгуулах	Туршлага судлах шатахуун 1,600,000 Хоолны зардал 900,000 Багшийн хөлс 1,000,000 Сургалтын материал үр бордоо 150,000 Шатахуун 400,000 Цайны завсарлага 800,000 Төсөл хөтөлбөрийн 2.4.66 зардлаас 4,850,000 гаргуулахаар батлуулсан. Шатахуун 2,000,000 Цайны завсарлага 799,157 Багшийн хөлс 1,000,000 Үр, бордоо 150,000 Хоолны зардал 900,843 Нийт зарцуулалт 4,850,000 төгрөг. Захирамжийн зорилго сургалт, туршлага судлах ажил зохион байгуулснаар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар хүлээгдэж буй үр дүнг тайланд нэмж тусгах.	-Гэрээнд хүчин төгөлдөр байдал хангах хууль эрх зүйн заалт байхгүй, зорилго бичигдээгүй, гэрээ дүгнэсэн акт байхгүй -Хоолны зардалд төлбөрийн хүсэлт

ДӨРӨВ: 2024 ОНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Гэрээ, хүлээлцсэн актад гарын үсэг, дугаар тавьж хэвших. -Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан.
2. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар дотоод хяналт хийхэд нийт 19 захирамжаас 10 захирамжийг хамруулаагүй, цаг хугацаандаа ажлаа хийх. - 2025 оны 11 сарын 15-ны байдлаар нийт 18 захирамжаас 10 материал ирсэн нь хангалтгүй, -Зөвлөмжийн биелэлт хангагдаагүй, алдааг дахин давтан гаргасан.
3. Он дамжин хэрэгжих арга хэмжээ, гүйлгээ дахин гаргахгүй байхад анхаарах. Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан. 2024-2025 онд дамжин хийгдсэн ажил байхгүй.
4. Захирамжаар баталсан төсвийг хооронд нь гүйлгэхгүй байх. Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан.
5. Гэрээ байгуулсан л бол дүгнэх хуудас, актаар гүйцэтгэл, үр дүнг тооцож хэвших. -Хэрэгжилт хангаагүй. Түрээсийн гэрээ, Сургалтын гэрээг дүгнэж, Бусдаар гүйцэтгүүлсэн гэрээний дүгнэсэн акт үйлдээгүй.
6. Захирамжийн зорилтыг хангахад чиглэж үйл ажиллагаагаа зохион байгуулах, үр дүн талаас нь тайлагнаж хэвших.-89% нь Захирамжийн зорилгын хэрэгжилт, үр дүнг тооцож тайлагнасан.
7. Гэрээг байгуулахдаа эрх зүйн талаас нь байвал зохих мэдээллийг гэрээнд тусгах. -75% нь гэрээг хянуулсан, 11% нь шаардлага хангаагүй гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн.

ДҮГНЭЛТ

2025 онд хэрэгжүүлэх 10 багц төсөл арга хэмжээний 882,000.0 мянган төгрөг батлагдсанаас 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 18 захирамжийн 268,685,000 төгрөгийн орлогын гүйлгээ хийгдэж, байгууллагын дансанд төвлөрсөн.

Дотоод хяналтад 9 захирамжийн 47,575,000 төгрөг, ХХААГ-ын үйл ажиллагаатай холбоогүй, 2024 оны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний шагналтай холбоотой 3,000,000 төгрөгийн 1 захирамж, нийт 10 захирамжийн 50,575,000 төгрөгийн хэрэгжилт хамрагдсан.

2024 оны тайлагналттай харьцуулахад Захирамжийн зорилтыг хангахад чиглэж үйл ажиллагаагаа зохион байгуулах, үр дүн талаас нь дэлгэрэнгүй тайлагнахад анхаарч ажиллажээ.

Өрхийн тариалалт, Үржлийн малд үзлэг ангилалт хийх, Намрын ногоон өдрүүд зэрэг захирамж нь цаг хугацааны хувьд дууссан, материал ирүүлээгүй, дотоод хяналтад хамруулаагүй нь ажлын хариуцлага, цаг хугацаандаа байх зарчим алдагдаж, Төсвийн тухай хуулийн 5.1.5, 6.3.2 дахь заалтыг тус тус зөрчиж байна.

Захирамжийн биелэлт, тайлан ирүүлээгүй албан хаагчдаас шалгаан, тайлбарыг өгөхийг шаардсан боловч хэрэгжүүлээгүй. Дотоод хяналтад хамрагдаагүй дараах захирамж байна. Үүнд:

№	Тэргүү, утга	Хариуцсан албан хаагч	Захирамжийн дугаар	Дотоод хяналтад хамруулаагүй тайлбар

1.	Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр	2025.02.11	A/92	-
2.	Малчдын өвөлжилт, хаваржилт, мал төлөлтийн явцтай танилцах	2025.03.12	A/170	-
3.	Үржлийн малд үзлэг ангилалт хийх	2025.03.26	A/223	-
4.	Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх	2025.06.13	A/452	Төлөвлөсөн ажил дуусаагүй хүлээгдэж байгаа.
5.	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих	2025.07.04	A/533	Сургалт зохион байгуулагдаж байна. Ажил дуусаагүй байгаа.
6.	Аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээл бэлтгэх	2025.09.05	A/720	-
7.	Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2025 нэгдсэн арга хэмжээ	2025.09.16	A/746	-
8.	Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн	2025.09.24	A/747	-

Тайлан бичихдээ Албан хэрэг хөтлөлтийн стандарт баримтлаагүй. MNS 5140-2:2021-ын 5.7 хэсгийн 3 дугаарт “Зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичиг 2021 оны 05 дугаар сарын 05 гэсэн загвараар тайлангийн огноог, тус стандартын 5.17 дахь хэсэгт гарын үсгийг зурахдаа албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал орох бөгөөд том үсгээр голлуулан бичнэ гэжээ. Тайлангийн зургийг эмх цэгцтэй оруулж байх шаардлагатай байна.

Гэрээ байгуулсан л бол гэрээ дүгнэсэн хүснэгт, акт үйлдэж байх.

Өмнөх оны дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай хангагдсан нь алдаагаа давтан гаргаж, ажлын чанар сайжрахгүй, дотоод хяналтын ач холбогдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Гэрээ, захирамжийн төслийг хянуулаагүйгээс эрх зүйн чадамжгүй гэрээ байгуулагдах, алдаатай захирамж гарах эрсдэл байна. Мөн жилийн эцэст өндөр дүнтэй, дотоод хяналт хийгдээгүй баримтууд аудитаар шалгуулж, акт, албан шаардлага тавигдах эрсдэлт нөхцөл үүсэж, өмнөх оны алдаа давтагдахаар байна.

ЗӨВЛӨМЖ

ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

- Захирамжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг цаг хугацаанд нь гүйцэтгүүлэхэд анхаарч тайланг тухай бүр бичүүлж, хаахад хяналт тавих
- Тайланг хянаж гарын үсэг зурахдаа Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, байгууллагын Архивын үйл ажиллагааны журамд нийцсэн эсэхийг хянаж байх.
- Байгуулсан гэрээний дүгнэлт, акт байгаа эсэхийг шалгаж, бүрдүүлэхэд анхаарах
- Зохион байгуулж байгаа үйл ажиллагаандаа зорилтот бүлгийг бүрэн хамруулахад анхаарч ажиллах /хүнсний аюулгүй байдлыг хангах, сурагч, бага насны

хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах чухал сургалтыг тасалсан 30 төрийн албан хаагч/

НИЙТ АЛБАН ХААГЧДАД

1. Гэрээ, захирамжийн төслийг хянуулж байх
2. Мөнгөн бичгийн Байнгын фондуудыг захирамжлал, мэдээлэл, паялгээний баримт бичгийг хөрвүүлж, MNS6395:2022 стандартыг мөрдөж ажиллах.
3. Анхаарах асуудал багананд тусгагдсан хариуцсан асуудлыг арилгах.

САНХҮҮГИЙН АЖИЛТНУУДАД

1. Төлбөрийн хүсэлт хавсаргах
2. Санхүүгийн баримт засваргүй байхад анхаарах
3. Мөнгөн шагналын зардалд иргэний үнэмлэх, гэрчилгээ хавсаргаж, анхан шатны баримтын бүрдэл хангах. Улмаар ХХОАТ-ын тайлан хийхэд зайлшгүй шаардлагатай баримт тул бүрдүүлж байх.

Дотоод хяналтад хамруулаагүй захирамжийн шалтгаан, тайлбар, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДОТООД АУДИТ ХИЙСЭН МӨРГӨЖИЛТНИЙ САНАЛ

Дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэж, хагас бүтэн жилийн үр дүнд нэг үзүүлэлт болгон тооцож, үнэлэх санал хүргүүлж байна.

ДОТООД ХЯНАЛТ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.БАТЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Ж.БАЯРМАНДАХ

ТАНИЛЦСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА



С.ДАВААДОРЖ

